



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 372

Улаанбаатар хот

Г “Блумсбюри секьюритис” ХХК-ийн тусгай
зөвшөөрлийг сунгах тухай Т

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 15.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Блумсбюри секьюритис” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд андеррайтер, брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2013 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Блумсбюри секьюритис” ХХК-ийн / Б.Мягмарсүрэн/-д үүрэг болгосугай.
 - 1/ Хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллах;
 - 2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;
 - 3/ Хорооны 2009 оны 251 дүгээр тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөх.
3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

БААНЫ
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ